



Боловсрол, Шинжлэх Ухааны Яамны харьяа

БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

#1(10)

2023 он

I сар

Сар тутмын хэвлэл

 <http://www.mnier.mn>

EDUTEN ПЛАТФОРМЫГ ТУРШИХ ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТЫГ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Үр дүнгээрээ дэлхийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Финланд улсын Eduten сургалтын платформыг турших, хэрэгжүүлэх ажилд үү оролцох багш нар, сургуулийн удирдлагууд, БШУГ-ын болон мэргэжлийн байгууллагын арга зүйч, мэргэжилтнүүд, судлаачдын сургалт хоёр өдрийн турш амжилттай, үр дүнтэй болж өндөрлөлөө.



Сургалтыг уг платформыг үүсгэн байгуулагч Финландын Турку их сургуулийн эрдэмтэн, судлаачид, платформыг хөгжүүлэгч eduten технологийн компанийн мэргэжилтнүүд, БСҮХ-ийн судлаачид хамтран зохион байгууллаа. Энэхүү ажил нь МУ-ын засгийн газар, БШУЯ-аас хэрэгжүүлж буй МХХТ-ийг сургалтад нэвтрүүлэх, сургалтын чанарыг сайжруулах ажлын хүрээнд БСҮХ -тэй хамтран хэрэгжүүлж буй ажлуудын нэг бөгөөд сурагчдад уг платформоор дамжуулан идэвхтэй, бүтээлчээр бие даан суралцах, тоглонгоо математик мэдлэг, чадвараа хөгжүүлэх боломжийг олгох зорилготой.



Уг туршилт-судалгаанд сум, аймаг, нийслэлийн 15 бүлгийн 520 сурагч хамрагдах ба цаашид бүх ЕБС-д тухайн платформыг ашиглах боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна.



“EDUTEN” платформ нь хиймэл оюун ухаан, тоглоомд суурилсан байдлаар боловсруулсан 200 мянга гаруй математикийн дасгал, даалгавруудын сантай, багш нарын ажлын ачааллыг бууруулах, математикийн хичээлийн чанар, үр өгөөжийг дээшлүүлэх ач холбогдолтой ухаалаг систем юм. Уг платформ нь ЮНЕСКО-ийн хиймэл оюун ухаанаар дамжуулж боловсролыг дэмжих шилдэг туршлагыг нэвтрүүлсэн бүтээлд олгодог “Боловсролын төлөөх ICT” шагналыг 2020 онд, ЮНИСЕФ-ийн “Онцлох Edtech” шагналыг 2022 онд тус тус хүртжээ.

‘PEARSON’ АНГЛИ ХЭЛНИЙ ХӨТӨЛБӨРИЙН СУРГАГЧ БАГШ НАР БЭЛТГЭГДЛЭЭ



2022-2023 оны хичээлийн жилийн хоёр дугаар хагас жилээс “Pearson” Англи хэлний туршилтын хөтөлбөрийг сонгогдсон 38 сургуульд хэрэгжүүлнэ.

Тус хөтөлбөрийн бэлтгэл ажлыг ханган “Үндэсний мастер сургагч багш” бэлтгэх сургалтыг Pearson боловсролын байгууллагын олон улсын зөвлөхүүд удирдан явуулж байна. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сертификат олгох энэ сургалтад орон нутаг, нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 40 багш, гадаад хэлний 18 мэргэжилтэн хамрагдсан байна.




Сургалтын үеэр БШУ-ы сайд Л.Энх-Амгалан: Энэ хамтын ажиллагааны хүрээнд Монгол сурагчдын болон багш нарын англи хэлний боловсролын чанарт мэдэгдэхүйц ахиц гарна гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлсэн.

“Англи хэлний энэ туршилтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд БШУЯ, БЕГ, БСҮХ, Pearson болон багш нар оролцсон 88 хүний бүрэлдэхүүнтэй хамтарсан менежментийн баг ажиллахаар болсон юм.



2023 ОНЫ СУДАЛГАА, АРГА ЗҮЙН АЖЛУУДАА ТӨЛӨВЛӨХ, БАТАЛГААЖУУЛАЛТЫН СУДАЛГААГ ХИЙГДЛЭЭ.



БСҮХ-ийн ХХСС-ийн эрдэм шинжилгээний ажилтнуудын хувьд 1-р сар нь жилийн ажлын төлөвлөгөөг дахин харж сайжруулах, судалгааны арга зүйн боловсруулалт, судалгааны бүтээлээ хэвлүүлэх ажил хийгдлээ.

“Монгол хүүхдийн бие бялдар, нийгэмшил, танин мэдэхүйн хөгжлийн онцлог” судалгааны үр дүнд үндэслэсэн бүтээл/монографыг хэвлэлтэд шилжүүлсэн. “ЕБС-ийн менежментийг дэмжих арга зүйн зөвлөмж”-ийн бүтэц агуулга тодорхой болж, зөвлөмж боловсруулах ажил эхлээд байна. Тусгай хэрэгцээт хүүхдийн хөгжлийн онцлогийг тодорхойлох судалгааны ажлын арга зүй тодорхой болж мэдээлэл цуглуулах бэлтгэл ажлыг хийж байна.

“Хүүхдийн хөгжлийн шалгуур, үзүүлэлтийн баталгаажуулалт”-ын судалгаанд СӨБ-ын 762 багш, ЕБС-ийн биеийн тамирын 254 багш, ЕБС-ийн 3411 багш хамрагдсан.



БАЙГУУЛЛАГЫН КОМПЬЮТЕРТ АЛБАН ЁСНЫ ЛИЦЕНЗТЭЙ АНТИВИРУСЫН ПРОГРАММ ХАНГАМЖ СУУЛГАВ



БШУЯ-наас кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2022 оны 10, 11 сард харьяа байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдлын үнэлгээг ТЕГ-аар хийлгэсэн. ТЕГ-аас БШУЯ-нд ирүүлсэн эрсдэлийн үнэлгээний тайлан, зөвлөмжид тусгагдсан нэг заалт болох “Байгууллагын бүх компьютерт албан ёсны лицензтэй антивирусын программ хангамж суулгах” зөвлөмжийн дагуу бүх ажилтны компьютерыг антивирусын программын лицензээр хангаж байна.

“TABLEAU” ПРОГРАММЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР



Байгууллагын судлаачдын цахим өгөгдлийн шинжилгээний мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгоор цахим сургалтыг 1 сарын хугацаатай дараах сэдвийн хүрээнд зохион байгууллаа.

1. Өгөгдлийн тухай ойлголт
2. Өгөгдлийг дүрслэх
3. Tableau программын ашиглалт
4. Тайлан, үр дүнг цахим хэлбэрт оруулах

МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ БОДЛОГО “АЛСЫН ХАРАА 2050”-ЫН СУРГАГЧ БАГШИЙН СУРГАЛТ

Урт хугацааны бодлогын цахим, танхим, цахим хэлбэрээр 10 хоногийн туршид хамрагдсан.

Сургалтад хамрагдсан БСҮХ-ийн сургагч багш нар “МУ-ын Урт хугацааны хөгжлийн бодлого”-ыг нийслэлийн 332 багш, удирдах ажилтнуудад 6 хоногийн хугацаанд амжилттай зохион байгууллаа.



ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, БОЛОВСРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Амьдралын мод” сургалтын хөтөлбөр болон дагалдах сургалтын хэрэглэгдэхүүн, цахим систем нь СӨБ-ын сургалтын чанар, хүртээмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх гол арга зүй нь “Зохиолд суурилсан нэгдмэл арга зүй” байдаг тул олон суралцахуйн зорилтыг нэг зохиолоор дамжуулан олгох боломжтой.

Энэхүү аргазүйн хүрээнд сургалтын хөтөлбөрийн хэрэглэгдэхүүнүүд нь хоорондоо уялдаа хамааралтай, тоглоом, үлгэр, бүтээлч үйл нь бүгд сургалт, үйл ажиллагаагаар олгох агуулгуудыг уялдаа хамааралтайгаар нэгтгэсэн байдаг.

Иймд энэхүү аргазүйг Монгол Улсад хэрхэн тохиромжтойгоор нэвтрүүлэх цаашлаад түгээн дэлгэрүүлэх боломжийг тандах ажлыг ийнхүү эхлүүлж байна.

СӨБ-ын сургалтын хөтөлбөрийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд тулгамдаж буй доорх хэрэгцээ шаардлагуудыг “Амьдралын мод” сургалтын хөтөлбөрөөр дамжуулан цогцоор нь шийдэх, боломжийг илрүүлэхээр зорьж байна. Үүнд:

1. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хэрэглэгдэхүүний хангалтыг чанаржуулах, нэмэгдүүлэх;
2. Хүүхдийн сурах, хөгжих үйл явцад туслах эцэг эх, гэр бүлийн хандлага, ур чадварыг дээшлүүлэх;
3. Үнэлгээний систем, тогтолцоог тогтмолжуулах.

СӨБ-ЫН БАГШИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЗӨВЛӨМЖ

Гүйцэтгэлийн үнэлгээний зөвлөмж боловсруулах ажлын хэсгийг БШУЯ, БҮТ, БЕГ болон цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйчийн төлөөллийг хамруулан байгуулав.

Үр дүн: Үндэсний хэмжээнд зохион байгуулсан цэцэрлэгийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд шинжилгээ хийж зөвлөмж боловсруулах ажлыг гүйцэтгэж байна.

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ ЗАРЛАГДЛАА

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 372 дугаар тогтоол, Боловсрол шинжлэх ухааны яамны сайдын 2022 оны А/145 дугаар тушаалаар батлагдсан "Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга хэмжээ"-г хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд ерөнхий боловсролын сургуулиудын Англи хэлний багш нарын мэргэжлийн ур чадвар, заах арга зүйг хөгжүүлэх, сургагч багш бэлтгэх дунд хугацааны сургалтад хамрагдах 30 багшийг сонгон шалгаруулсан.

Сургалт 3 сар танхимаар хичээллэх бэлтгэл ажил хийгдсэн байна.

СУРГАЛТ

Монгол хүүхдийн академик үгийн сангийн нөөцийг тогтоох, түвшинчилсэн үгийн сангийн жагсаалт гаргах судалгаа БСҮХ-ийн МХБСАТ-д ХБҮЗ-ийн захиалгаар 2022 оны 12 сард албан ёсоор эхэлсэн юм. Энэхүү ажлын хүрээнд судлаачдыг чадавхжуулах 3 удаагийн сургалтыг цахим хэлбэрээр амжилттай зохион байгууллаа.

I. Эхний сургалтаар СӨБ судлаач Доктор (PhD), дэд профессор Ц.Наранцэцэг “Сургуулийн өмнөх насны хүүхдийн үгийн нөөцийг судлах нь” сэдвээр хичээл заав.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛИЙН
ИХ СУРГУУЛЬ

СУРГУУЛИЙН ӨМНӨХ
НАСНЫ ХҮҮХДИЙН ҮГИЙН
НӨӨЦИЙГ СУДЛАХ НЬ

Доктор (Ph.D), дэд профессор Ц.Наранцэцэг

2023.01.11

Дотоод болон гадаадын үгийн сангийн харьцуулсан судалгааны үр дүн болон хүүхдийн хэл эзэмших үйл явцын талаар дэлгэрэнгүй танилцуулав. Мөн хүүхдийн үгийн нөөцийн өсөлтийг тодорхойлж, үгийн сангийн нөөцийг тогтоох арга аргачлалаас танилцууллаа.

II. 2 дахь сургалтаар МУБИС-ийн Монгол судлалын төвийн эрхлэгч, монгол улсын гавьяат багш, доктор, профессор Ц.Өнөрбаян “Хүүхдийн үгийн сангийн нөөцийг тогтоох туршилтын аргазүй” сэдвээр хичээл заалаа. Бага насны хүүхдийн хэл эзэмшихүйн үйл явцыг олон баримт, нотолгоонд суурилан тайлбарласан сонирхолтой, үр өгөөжтэй хичээл болов.

Хэл эзэмшихүйг сэтгэц хэл шинжлэлтэй холбон үзэж, үгийн сангийн нөөцийг

тогтоох туршилтуудын талаар танилцуулсан юм.

III. 3 дахь сургалтаар МХХТС-ийн салбарын эрхлэгч доктор А.Хүдэр “Өгүүлбэр дэх үгийн аймгийг тодорхойлох компьютерын загвар боловсруулах нь” хичээлээрээ үгийн сан хөмрөг бий болгож, утга үүргийн талаас шинжилгээ хийх орчин үеийн шинэлэг арга туршлагаудаас хуваалцлаа.

Сургалтад БСҮХ-ийн 25 эрдэм шинжилгээний ажилтнууд хамрагдаж, цаашдын судалгааны мэдээлэл цуглуулахад болон эрдэм шинжилгээний туршилтад онцгой ач холбогдолтой сургалт болсныг тэмдэглэлээ.

МОНГОЛ УЛСЫН ИНЖЕНЕР ТЕХНОЛОГИЙН ДЭЭД БОЛОВСРОЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХЭТИЙН ТӨЛӨВ

Энэхүү судалгаагаар бид Монгол инженер технологийн дээд боловсролын өнөөгийн байдал, хэтийн төлөвийг тодорхойлохын тулд манай улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүд, энэ чиглэлээр мэргэжлээр суралцагчдын сүүлийн 5 жилийн судалгааны тоон болон статистик мэдээлэл, 86 ДБСБ-уудаас авсан судалгааны мэдээлэлд тоон болон чанарын шинжилгээ хийлээ. МУ-ын хэмжээнд Инженер технологийн дээд боловсролтой дээд мэргэжилтний хөдөлмөрийн зах зээл дээр эрэлт өсөх төлөвтэй байгаа тул цаашид мэргэшсэн инженер техникийн ажилтнуудыг бэлтгэх материаллаг болон хүний нөөцийн төлөвлөлтийг эдийн засгийн идэвхтэй салбаруудыг хөгжлийн бодлоготой уялдуулан хөгжүүлэх шаардлагатай байна.

ТАНИЛЦУУЛГА

Монгол улсад 1995 оноос Дээд боловсролын тухай хуулийг анх баталж, 2002, 2006, 2012, 2015, 2016 онуудад өөрчлөлт оруулсны дагуу дээд боловсролын дөрвөн шатлалтай (диплом, бакалавр, магистр, доктор) тогтолцоо хэрэгжиж байна. Дээд боловсролын сургалтын байгууллага (ДБСБ) нь энэхүү хуульд заасны дагуу бие даасан хуулийн этгээд байх ба их сургууль, дээд сургууль, коллеж, технологийн коллеж гэсэн ангилалтай байна.

Манай улсад үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, коллежийн тоо 2020-2021 оны хичээлийн жилд 88 байна. Эдгээрийн 37 (42.1 хувь) нь их сургууль, 45 (51.1 хувь) нь дээд сургууль, 3 (3.4 хувь) нь коллеж, 3 (3.4 хувь) нь гадаадын их сургуулийн салбар байна. Үүний 65 (73.9 хувь) нь төрийн бус өмчийн, 20 (22.7 хувь) нь төрийн өмчийн, 3 (3.4 хувь) нь олон нийтийн / шашны 1 өмчийн сургууль

байна. Нийт сургуулийн 79 (89.8 хувь) нь Улаанбаатар хотод, 9 (10.2 хувь) хөдөө, орон нутагт байна.

2021-2022 оны хичээлийн жилд сургуульд нийт 148.954 суралцагч суралцаж байна. Эдгээр суралцагчдын 12.8 хувийг Инженер, үйлдвэрлэл, барилга угсралтын мэргэжлийн чиглэлийн суралцагчид эзэлж байна. Энэ чиглэлийн 137 хөтөлбөрөөр нийт 19083 оюутан суралцаж байна. Эдгээр суралцагчдын 13966 буюу 73.1 хувь нь цахилгаан, эрчим хүч (4925), иргэний ба үйлдвэрийн барилга байгууламж (3725), архитектур, хот төлөвлөлт (1819), механик, төмөрлөгийн үйлдвэрлэл (1788), уул уурхай олборлолт (1709) зэрэг 5 нарийвчилсан чиглэлээр суралцагчид байна. Харин боловсролын түвшнээр авч үзвэл дипломын 204, бакалаврын 16646, магистрын 1980, докторын түвшний 253 оюутан тус тус суралцаж байна.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгааны зорилго нь Монгол инженер технологийн дээд боловсролын өнөөгийн байдалд шинжилгээ хийж, дээд боловсролын салбарын бодлого үйл ажиллагаанд тусгах санал зөвлөмж боловсруулахад чиглэсэн юм.


Нэгдсэн тоон мэдээллийг MS EXCEL программд кодын дагуу шивж оруулан механик болон логик алдааг шалгаж, чанарын шаардлагад нийцүүлэн, судалгааны SPSS 23.0 программ ашиглан мэдээллийн дүн шинжилгээ, боловсруулалт хийлээ. Тоо, хувиар илэрхийлэгдэх дан тоолол болон оролцогчдын хүчин зүйлсийн харьцуулсан дүн шинжилгээ хийсэн болно.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

БСШУ-ны сайдын 2014 оны А/178, А/370 тушаалаар хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагыг баталж, сургалт эрхлэх хөтөлбөрийн нэр, индексийг БСШУ-ны сайдын 2014 оны А/78 тушаалаар батлан хэрэгжүүлж байна.


Судалгаанд оролцсон 86 их дээд сургууль нийт бакалаврын, магистрын болон докторын хөтөлбөр хэрэгжүүлж байна. Үүнээс, төрийн өмчийн 20 их дээд сургууль 774 (49.9 хувь), төрийн бус өмчийн 64 их дээд сургууль 692 (44.6 хувь) хөтөлбөрөөр сургалт зохион байгуулжээ (2020-2021 оны хичээлийн жил)

График 1. ДБСБ-ын тоо. Өмчийн хэлбэр



2020-2021 оны хичээлийн жилд үйл ажиллагаа явуулж буй 88 ДБСБ-ын 18.2 % нь төрийн өмчийн, 68.2% нь төрийн бус өмчийн, 3.4 % нь гадаадын салбар сургууль байна. Дээд боловсролын сургалтын 88 байгууллагаас 80 нь Улаанбаатар хотод, 8 нь хөдөө орон нутагт байрлаж байна.

График 2. ДБСБ-ын тоо. Хэв шинжээр



Харин ДБСБ-ын хэв шинжээр үзэхэд, их сургуулиуд 71.2 дээд сургуулиуд 21.2 хувь, коллежууд 0.6 хувь гадаад хөрөнгө оруулалттай дээд сургууль 1.5 хувь, гадаад хөрөнгө оруулалттай дээд сургууль 0.1

хувь нийт хэрэгжиж буй хөтөлбөрүүдээр сургалт зохион байгуулж байна.

График 3. Хөтөлбөрийн тоо. Сургуулийн хэв шинжээр



Төрийн өмчийн ИДС-аас хамгийн олон хөтөлбөр хэрэгжүүлж байгаа сургууль бол ШУТИС-183 хөтөлбөртэй, харин МУИС – 118 хөтөлбөрөөр сургалт зохион байгуулж байна. Хөтөлбөрийн нийт тоо 1466 байгаагаас төрийн өмчийн 692, төрийн бус өмчийн 774 хөтөлбөр байна.

Төрийн бус өмчийн ИДС-аас хамгийн их хөтөлбөр хэрэгжүүлж байгаа сургууль бол Монголын үндэсний их сургууль-68 хөтөлбөртэй, Их засаг олон улсын их сургууль-31 хөтөлбөртэй, Хүмүүнлэгийн ухааны их сургууль-29 хөтөлбөрөөр сургалт зохион байгуулж байна. Бидний хийсэн хөтөлбөрийн давхцалын шинжилгээний үр дүнгээс инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт судлагдахуунаар хамгийн их сургалт зохион байгуулж байгаа нь харагдлаа.

Хүснэгт 1. Инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлтийн чиглэлээрх хөтөлбөрийн давхцал

Хэрэгжүүлж байгаа хөтөлбөрийн тоо	Хөтөлбөр хэрэгжүүлдэг сургуулийн тоо	Хувь
1	113	69.3
2	16	9.8
3	11	6.7
4	10	6.1
5	1	0.6
6	1	0.6
7	1	0.6
8	1	0.6
9	2	1.2
13	4	2.5
19	1	0.6
Нийт-163	333	

Инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт чиглэлээр хамгийн их буюу 345 (22.3 хувь) хөтөлбөр хэрэгжиж байна.

Тиймээс энэхүү чиглэлээр төгсөн гарч буй оюутнуудыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан тухайн мэргэшлийн дагуу хэр зэрэг нийцтэй ажиллаж байгааг тодруулахыг зорилоо.

График 4. Хөтөлбөрийн давхцал, хөтөлбөрийн нэрээр, хөтөлбөр хэрэгжүүлдэг сургуулийн тоогоор



График 4-өөс харахад барилгын инженер, архитектур, уул уурхайн ашиглалтын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг сургуулиуд тоогоороо тэргүүлж байна. Монгол Улсын хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн 2021 оны барометрийн судалгаанаас үзэхэд 2022 онд ажиллах хүчний эрэлт хамгийн их байх салбар нь өмнөх жилүүдийн адил худалдаа, барилга, боловсруулах үйлдвэрлэл, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээний салбар болж байна.

Сүүлийн 12 сард ажилд орсон нийт ажиллагчдын 12.7 хувь нь барилгын салбарт, 9.8 хувь нь боловсруулах үйлдвэрлэлийн салбарт, 8.5 хувь нь боловсролын салбарт ажилд орсон нь сүүлийн 12 сард шинээр ажилд орсон нийт ажиллагчдын 31.0 хувь болж байна. Судалгаагаар инженер технологийн салбарт шаардлагатай ажиллагсдын хувь өндөр байгаа нь нэг талаасаа энэ хөтөлбөрөөр бэлтгэгдэн гарч байгаа хүний нөөцийн зохистой харьцаа хангагдаж байна гэж харах хэдий ч бодит байдал дээр нарийн мэргэжил, боловсрол, ур чадвар шаардахгүй энгийн ажил мэргэжлийн ажиллах хүчний эрэлт нь нийт эрэлтийн ихэнх хувийг бүрдүүлдэг үзэгдэл байсаар байна. Өөрөөр хэлбэл, барилга болон үйлдвэрлэл аж ахуйн туслах ажилтан, цэвэрлэгч, харуул хамгаалалтын ажилтан нь сүүлийн 10 жил эрэлттэй ажил мэргэжлийн жагсаалтад тогтмол дурдагдаж байна.

Энэ нь эдгээр ажил мэргэжлийн ажиллагчдын шилжилт хөдөлгөөн их, хөдөлмөр эрхлэлт тогтворгүй байдагтай шууд хамааралтай. Хөгжиж буй ихэнх орнуудад гол төлөв боловсрол эзэмшээгүй хүн ам ажилгүй байдаг бол манай улсад боловсролтой иргэд илүү ажилгүй байх хандлагатай байна. Нөгөө талаас мэргэжлийн болон дээд боловсролд хамрагдалт өндөр байгаатай холбоотой.

нэгдүгээрт, зарим сургуулиуд төгсөгчдийн ажил эрхлэлтийн мэдээгээ бүрэн гаргаж чадахгүй байгаа, хоёрдугаарт, төгсөгчид төгссөн үедээ тэр бүр ажлын байртай болж амжихгүй байгаатай холбоотой гэж үзсэн байна.

График 6. Магистрын болон докторын түвшинд суралцагчдын тоо (2016-2021 он)



Хүснэгт 2. Судалгааны түвшинд суралцагчдын тоо дипломын, бакалаврын түвшинд түвшинд суралцагчдын тоо (2016-2021 он)

Хөтөлбөрийн нэр	Диплом, Бакалавр	Доктор, магистр	Хувь
Байгаль орчныг хамгаалах технологи	1392	77	5.5
Цахилгааны инженер	9619	97	1
Цахилгаан хангамж	409	34	8.3
Механик инженер	1988	23	1.2
Хүнсний инженерчлэл	3023	0	0
Уул уурхайн ашиглалтын технологи	3912	602	15.4
Ашигт малтмалын баяжуулалтын технологи	1702	131	7.7
Газар зохион байгуулалт (төлөвлөлт, кадастр)	2150	1080	50.2
Архитектур	6008	188	3.1
Барилгын инженер	15186	176	1.2

Хүснэгт 2 тооны харьцаанаас харахад дээр дурдсан хөтөлбөрөөр суралцагсад буураагүй нь харагдаж байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институтээс гаргасан 2019 оны судалгаанаас эзэмшсэн

мэргэжлийнхээ дагуу 2017 онд хөдөлмөр эрхэлж байсан төгсөгчдийн 83.8 хувь нь хөдөлмөр эрхэлсэн хэвээр, 2.0 хувь нь ажилгүй болсон, 14.2 хувь нь эдийн засгийн идэвхгүй төлөвт шилжсэн байна.

Төгсөгчдийн ажлын байранд хамгийн их тулгарч буй ур чадварын хомсдолын нэг нь гадаад хэлний мэдлэг бөгөөд түүний хэрэгцээ шаардлага жил ирэх тутам нэмэгддэг байна. Түүнчлэн төгсөгчдөд тулгарч буй ур чадварын хомсдолд мэргэжлийн ур чадвар, багаар ажиллах чадвар зэрэг нь нэлээдгүй хувийг эзэлсээр байна. Харин шинжлэх ухаан технологийн мэдлэг, мэдээллийн технологийг ашиглах, эзэмших зэрэг ур чадварууд нь ажлын байранд гарсан эхний жил тодорхой хувийг эзэлдэг ч, хугацаа өнгөрөх тусам дутагдах ур чадварт орох хувь нь багасаж байна.

Төгсөгчдийн 28.6 хувьд нь боловсролын үл нийцлээс хамаарсан бэрхшээл байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 2.6 пунктээр нэмэгдсэн дүн юм. Сургууль төгссөнөөс хойш гурван жилийн дараах байдлаар хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдөд багаар ажиллах, цаг ашиглах, харилцааны, зохион байгуулах, шийдвэр гаргах зэрэг зөөлөн ур чадварууд хамгийн ихээр дутагджээ. Гурван жилийн хугацаанд төгсөгчдөд гадаад хэлний, компьютерын, бичиг баримт боловсруулах, мэргэжлийн мэдлэг, чадвар илүү дутагдсан байна.

ДҮГНЭЛТ

1. Инженер технологийн чиглэлийн хөтөлбөрүүдэд зөвхөн 1 хөтөлбөрөөр сургалт явуулдаг ИДС-ын хувь өндөр байгаа нь энэ чиглэлийн хөтөлбөрүүд давхардал багатай байгааг харуулж байна. Гэтэл нөгөө талаас энэ чиглэлийн хүний нөөцийн эрэлт хэрэгцээ их байгаа нь ХЗЗ-ийн судалгаа, мэргэжлийн байгууллагуудын мэдээлэл харуулж байна.
2. Газар зохион байгуулалт (төлөвлөлт, кадастр)-ын чиглэлээр магистр түвшинд суралцагчдын тоо бакалавр, дипломын түвшинд суралцагчдын тоо хамгийн өндөр хувьтай байгаа нь энэ чиглэлийн судалгаа, шинжилгээ хийх хүний нөөц бүрдсэн байгааг харуулж байна.
3. Монгол улсын урт, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, зорилтын хэрэгжилтэд инженер, технологийн дээд боловсролтой мэргэжилтний эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэх хандлагатай байна.
4. Барилга, инженерийн мэргэшүүлэх хөтөлбөрөөр боловсон хүчин бэлтгэгдэж гарсаар байгаа хэдий ч төгсөгчдийн тогтвортой бус ажил эрхлэлт, ажлын байран дахь ур чадварын дутагдал зэргээс шалтгаалаад эдийн засгийн идэвхгүй төгсөгчид байсаар байгаа бөгөөд цаашид эдгээрт нөлөөлж буй хүчин зүйлийн судалгааг нарийвчлан гаргаж сөрөг үр дагаврыг бууруулах чиглэл баримтлан ажиллах хэрэгтэй байна.